

# ДАРХАН-УУЛ АЙМАГТ “СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТУХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.09.08-11-ний өдрүүд



2022.09.16

**ДАРХАН-УУЛ АЙМАГТ “СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ  
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТАЛААР УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ  
ХИЙЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ**

Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдөр”-ийн жагсаалтын 2 дугаар бүлгийн 2.31-д Соёл, урлагийн ажилтны өдрийг жил бүр 9 дүгээр сарын 2 дахь ням гарагт тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан.

Түүхэн үйл явдал, ой тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.2-д “Салбарын болон зарим мэргэжлийн ажилтан ажилчдын өдрийг тэмдэглэх хүрээнд тухайн жилд тодорхой сэдэв уриан дор дараах арга хэмжээг зохион байгуулж болно”, 2.3-д Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана’ хэмээн заасан.

Соёл, урлагийн ажилтны 29 дэх өдрийг Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 08-наас 9 дүгээр сарын 10-ны өдрүүдэд “Хандлагаа өөрчилье -Хамтдаа бүтээцгээе” уриан дор “Соёлын орон зай”-г бий болгосон олон талт үйл ажиллагааг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Соёл, урлагийн газрын даргын баталсан Удирдамж, Бэлтгэл ажлын төлөвлөгөө, Брэнд бүүкийг соёл, урлагийн байгууллагуудад болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод хүргүүлж ажиллав.

ЗГХА-СУГ-аас 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан Соёл, урлагийн ажилтны өдрийн талаарх цахим хуралд оролцож хурлаас өгсөн чиглэлийн дагуу соёл, урлагийн байгууллагуудад чиглэл өгч Удирдамж, төлөвлөгөө, брэнд бүүк, Бүтээлч хотын соёлын орон зай бүрдүүлэх уриалгыг танилцуулсан.

***Удирдамж, Бэлтгэл ажлын төлөвлөгөөг хавсаргав/***

“Соёлын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, яамны шагнал олгох журам батлах тухай” Соёлын сайдын 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр баталсан А/05 дугаар тушаалын дагуу “Жуух бичиг”, “Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”, “Ардын авьяастан хүндэт тэмдэг”-ээр шагнуулах нэр бүхий соёлын ажилтны тодорхойлолт, албан бичгийг Соёлын яамны Төрийг Захиргааны удирдлагын газарт, Дархан-Уул аймгийн Засаг даргын шагнал Тэргүүний ажилтан, Засаг даргын жуух бичиг, Дархан хот байгуулагдсаны 60 жилийн ойн Дурсгалын тэмдгээр шагнуулах нэр бүхий соёлын ажилтны тодорхойлолт, албан бичгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлж ажилласан.

Соёл, урлагийн ажилтны 29 дэх өдөрт зориулсан үйл ажиллагаануудад аймгийн Соёл, урлагийн газар, Залуучууд театр, аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Салбар номын сан, Хонгор сумын Соёлын төв, Орхон сумын Соёлын төв, Шарын гол сумын Соёлын төв, МСНЭ-ийн Дархан салбар, МЗЭ-ийн Дархан салбар зөвлөл, Зураач, урчуудын холбоо, Аялал жуулчлалын нэгдсэн холбоо, СӨБ, ЕБС-ийн Хөгжмийн багш нар, Бүжгийн холбоо, Гэрэл зурагчдын холбоо, Монгол II загварын агентлаг, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхэд хөгжлийн дугуйлангууд, Залуучууд театрын дэргэдэх Шонхоодой ардын цирк, Угалз уран нугаралтын төв, Чөлөөт уран бүтээлчид зэрэг нийт 260 гаруй уран бүтээлчид, ажилтан, албан хаагчид оролцсон.



**Соёл, урлагийн ажилтны өдрийг нийгэм, хүмүүнлэгийн ажлаар эхлүүлж эх хүүхдүүдэд хүндэтгэл үзүүллээ. Үүнд:**

**2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр:** Соёлын салбарын удирдлагууд Дархан хотын ирээдүйн эзэд болох шинэ иргэд нярай ээжүүдэд хүндэтгэл үзүүлжээ.

Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасагт 2022.09.07-08-ны өдрүүдэд 4 шинэ иргэн мэндэлжээ. Төрсөн болон төрсний дараах, эмчилгээ хийлгэж байсан нийт 30 ээж, тус тасгаар үйлчлүүлж 4 нийт 34 ээж хүүхдэд соёлын салбарынханы мэндчилгээ, сэтгэлийн бэлгийг гардуулав. Мөн Залуучууд театрын уран бүтээлчид ая дуугаа өргөж уран бүтээлээрээ бэлэг барьлаа.





## **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРААС ТӨРӨН ГАРСАН ЭДҮГЭЭ ДАРХАН ХОТОД АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БУЙ ГАВЬЯАТУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ**

**2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр:** Өнөөдрийн байдлаар нийт таван гавьяат цолтон төрөлх Дархан хотдоо ажиллаж амьдарч байна. Тэдгээр алдартнууддаа соёл, урлагийн байгууллагын удирдлагууд гэнэтийн бэлэг барьж хүндэтгэл үзүүллээ.

Тодруулбал:

- Монгол Улсын Гавьяат жүжигчин, дуучин Г.Алтанцэцэгт Залуучууд театрын дарга А.Болорсүх,
- Монгол Улсын Гавьяат жүжигчин, дуучин Д.Дагийсүрэнд Хүүхдийн номын ордны захирал Л.Мөнхбаатар,
- Монгол Улсын Гавьяат жүжигчин, бүжигчин С.Соёл-Эрдэнэд Төв номын сангийн дарга Б.Цэцэгсүрэн,
- Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч, яруу найрагч М.Хунлиузид Музейн дарга Д.Жамбалдорж,
- Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч Ө.Рагчаасүрэнд Соёл, Урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ нар хүндэтгэл үзүүлж баярлууллаа.



## “СОЁЛЫН ОРОН ЗАЙ-СПОРТЫН БАГА НААДАМ”-Д 15 БАГИЙН 150 ГАРУЙ ТАМИРЧИН ОРОЛЦЛОО

**2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр:** Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын дунд зохион “Соёлын орон зай - Спортын бага наадам” зохион байгууллаа.

Тэмцээн **гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, дартс, шатар** зэрэг 5 төрлөөр зохион байгуулагдсан. Тэмцээнд оролцсон байгууллагууд:

1. Аймгийн Соёл, урлагийн газар
2. Залуучууд театр
3. Музей
4. Хүүхдийн номын ордон
5. Төв номын сан
6. Шарын гол сумын Соёлын төв
7. Орхон сумын Соёлын төв
8. Хонгор сумын Соёлын төв
9. Зураач, урчуудын холбоо
10. МСНЭ-ийн Дархан салбар
11. Дарханы Гэрэл зурагчдын холбоо
12. Чөлөөт уран бүтээлчид /ЧУБ/
13. Монгол 2 загварын агентлаг
14. СӨБ, ЕБС-ийн дуу хөгжмийн багш нарын баг

15. Бүжгийн холбоо зэрэг нийт 15 багийн 150 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаа, оюун ухаанаа сорин оролцсон.

Спортын баг наадмын шилжин явах ЦОМын эздээр СӨБ, ЕБС-ийн дуу хөгжмийн багш нарын баг тодорч, Хонгор сумын Соёлын төвийнхөн удааллаа. Гуравдугаар байранд Бүжгийн холбооны баг тамирчид шалгарсан юм.

Энэ жилийн спортын тэмцээнийг түрүү жилийн цомын эзэн баг болох Залуучууд театрын хамт олон хариуцан зохион байгууллаа.





Энэ жилийн спортын тэмцээний онцлог нь оролцогч баг, тамирчдын тоо нэг дахин нэмэгдсэн, соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус байгууллагуудын идэвх оролцоо нэмэгдсэн явдал байв.

### СОЁЛЫН ОРОН ЗАЙ-НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

**2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр:** Соёл, урлагийн ажилтны 29 дэх өдрийг тохиолдуулан Найрамдал талбайд “Соёлын орон зай - Нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Өдөрлөгийн нээлтэд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Соёл, Урлагийн

газрын Х.Соёл-Эрдэнэ нар соёл, урлагийн байгууллагуудын удирдлагууд, нийт уран бүтээлчид, ажилтнуудад болон соёл, урлагийн салбараас төрсөн Гавьяатууд, Дархан хотын иргэд, хүүхэд залууст баяр хүргэж мэндчилгээ дэвшүүллээ. Нээлтийн үеэр УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан хэлсэн үгэндээ:

- Соёлын тухай хуульд Соёлын үйл ажиллагаан дахь иргэн, соёлын ажилтны эрх, үүрэг, аж ахуйн нэгж байгууллага, олон нийтийн оролцоог тусгайлан зааж, нийгмийн харилцаанд эерэг нөлөө үзүүлэх, соёлын илэрхийллийг таниулах, соёлын аялал жуулчлалын бүрэлдэхүүн хэсэг болох соёлын орчин, орон зайг хөгжүүлэх зохицуулалтыг тусгасан байдаг. Иймд орон нутагтаа тэр дундаа Дархан хотын хуучин Дарханы иргэдэд соёлоор үйлчлэх, тэнд соёлын орон зай бүрдүүлэхэд чиглэж ажиллахыг сануулж, орон зайг бий болгох ажлыг өрнүүлэн хэрэгжүүлэхэд зориулж 500.000.000 /таван зуун сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ.



Мөн үеэр Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр нэр бүхий 4 хүнийг шагналаа. Мөн Ардын авьяастан цол тэмдэг, соёлын яамны Жуух бичиг болон аймаг, сумын Засаг даргын Жуух бичиг, аймгийн Тэргүүний ажилтан цол тэмдэг, “Дархан-60” ойн медалиар нэр бүхий 28 хүнийг шагнаж урамшууллаа.







“Соёлын орон зай - Нээлттэй өдөрлөг”-өөр соёл, урлагийн салбарынхан өөр өөрсдийн онцлог бүтээлээрээ оролцож, уран бүтээлээ тайлагналаа. Тухайлбал: Залуучууд театрын уран бүтээлчдийн тоглолт, бүжгийн клубүүдын тоглолт, ГБХЗХГ-ын дэргэдэх дугуйлангийн сурагчдын тоглолт, Уран нугаралтын клубуудын үзүүлбэр, МЗЭ-ийн Дархан салбар зөвлөлийн яруу найрагчдын Найргийн дугараа, Загварын агентлагийн үзүүлбэр, Чөлөөт уран бүтээлчдийн тоглолт, үргэлжлүүлээд өсвөр үеийнхэнд зориулсан OPEN MIC зэрэг тайзны тоглолтууд үдэш 20:00 цаг хүртэл үргэлжилэв.



Мөн Зураач урчуудын холбоо, Гэрэл зурагчдын холбоо, МЗЭ-ийн Дархан салбар, соёлын бүтээлч үйлдвэрлэгчид зурсан, урласан, бүтээсэн, үйлдвэрлэсэн бүхнээ дэлгэн толилууллаа.



**Аймгийн Төв номын сангаас** Соёлын орон зай нээлттэй өдөрлөгт оролцогч иргэд, уншигчид болон хүүхэд багачууд зэрэг 100 гаруй хүнд Угийн бичиг, Угийн бичгийн ач холбогдол, түүнийг хэрхэн хөтлөх талаар сургалт явуулав.

Мөн өөрт байгаа уншсан, суралцаж, хэрэглэж дууссан ном, сурах бичгүүдээ өгөөд үзэсгэлэнд тавигдсан номнуудаас сольж авах "Ном солилцоо"-г зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэгээр Төв номын сангийн Ном зүйч, Мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр, Дархан хотын 60 жилийн ойн медалиар ахмад ажилтан С.Лхамсүрэн, Б.Бадамханд, Дя.Сарантуяа, Н.Солонго нар шагнуулсан.

Мэргэжил сурталчилах зорилгоор Номын санчийн **ХИШИГ ӨДӨР** зохион байгуулав. Хишиг өдөрт Аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Аймгийн ИТХ-ын дарга, Ахмадын хөгжлийн төвийн дарга А.Янжмаа, Дархан сумын Засаг дарга Т.Тулгаа, Дархан сумын ИТХ-ын төлөөлөгч, Аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга Д.Соёлтуяа, Дархан сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Батцэцэг нар оролцож номын санчийн ажлын онцлогтой танилцсан.





**Аймгийн Хүүхдийн номын ордноос** Шинэ номын үзэсгэлэн, хуучин номын худалдаа, Уншигчийн карт хөнгөлөлтэй нээх үйлчилгээ, Гэрээр ном олгох үйлчилгээ, "Яруу найргийн цаг" гэх мэт олон талт үйл ажиллагаа зохион явуулж иргэд, хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг сурталчиллаа. Мөн Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдгээр:

- 15 дугаар сургуулийн 7-А ангийн сурагч Ган-Очирын Ганди
- 15 дугаар сургуулийн 5-Д ангийн сурагч Ган-Очирын Чинболд
- 15 дугаар сургуулийн 3-в ангийн сурагч Ган-Очирын Чин-Үйлс нарын эгч дүү гурван шилдэг уншигчийг шагнаж урамшуулав.



Соёлын орон зай нээлттэй өдөрлөгт аймгийн **Музейн** хамт олон "Угсаатны зүйн үзмэрүүд" гэрэл зургийн үзэсгэлэн, "Мандала" олон нийтийн хөтөлбөр, "Хорол", "Үйчүүр" уламжлалт тоглоом наадгайг хүүхэд багачуудад сурталчилан таниулах боловсролын хөтөлбөр тус тус зохион байгууллаа. Дээрх хөтөлбөрүүдэд 200 гаруй хүүхэд багачууд хамрагдлаа.

Мөн Музейн мэргэжлийн ажилтнуудын ажлын байрны үүрэг хариуцлагыг таниулах, сурталчлах, музейн үзмэрийг музейд хэрхэн бүртгэдэг, музейд үзмэр хэрхэн хадгалагддаг, хэрхэн үзэгчдийн хүртээл болгодог тухай дадлага ажлыг бодит үзмэр дээр тулгуурлан иргэд, хүүхдүүдэд танилцууллаа.



Соёл, урлагийн ажилтны өдрийн утган Соёлын орон зай бий болгох уриалгад Дархан-Уул аймгийн Зураач Урчуудын Холбооны тэргүүн Н.Хишигбаатар нэгдэж 2011 оноос хойш сэргээн засварлагдаагүй байсан "Сарлаг унасан бүрээч хүү" хөшөө дурсгалыг өөрийн санхүүжилтээр сэргээн засварлаж хүлээлгэж өгөв.

Энэхүү баримлыг уран барималч О.Пүрэвсүрэн 1978 онд урласан юм.



Соёлын орон зай өдөрлөгт **Зураач, урчуудын холбоо** нь уран бүтээлийн үзэсгэлэнг толилуулахын зэрэгцээ монгол зургийн аргаар бүтээсэн Чингис хааны эш хөргийг аймгийн Соёл, урлагийн газарт бэлэглэв.



## СУМДАД “СОЁЛЫН ОРОН ЗАЙ - НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛАВ

**2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр:** Аймгийн Соёл, урлагийн газрын даргын баталсан удирдамжид заасны дагуу Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвүүдээс эрхлэн сумдын иргэд, ААНБ-ыг хамруулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулж, соёлын тухай хуулийн 30 дугаар зүйл. Соёлын орчин, орон зайг хөгжүүлэх тухай хуулийн заалтыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчиллаа. Тухайлбал:

**Шарын гол сумын Соёлын төв нь** Соёл, урлагийн ажилтны өдрийг угтан:

- Ахмад уурхайчин Ц.Төмөрхуягийн шүлэг, Залуу ая зохиогч Д.Бердбекеын аялгуу "ШАРЫН ГОЛ" дууг сурч, дуулах уриалга /челленж/,
- "Нарны тойрон бүжиг"-ийг СУИС-ийн багш, МУСТА доктор М.Мөнгөнцэцэг багшийн зааснаар сурч бүжиглэх уриалгыг нийт иргэд, ААН, албан байгууллага, ЕБС-ийн сурагчдын дунд өрнүүлэв.
- Боловсролын байгууллагуудын багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн
- Боловсрол, мэдээлэл, хүүхэд хөгжил төвөөс “НОМ УНШВАЛ УХААН ТЭЛНЭ” уншлага
- Номын солилцоо /Хуучин болон сурах бичиг/
- Нийтийн бүжиг заах
- Дугуйлан сургалтуудын танилцуулга /Дуу, бүжиг, хөгжим, зураг зэрэг/
- Бид хотын соёлтой иргэд” илтгэл
- “Урлагийн наадам”-ын шалгаруулалт
- Шагнал гардуулах үйл ажиллагаа / Соёлын яам болон аймаг, орон нутгийн шагнал гардуулах, Тэргүүний уншигч хүүхэд, насанд хүрэгчийг шалгаруулах/
- Сэтгэл ханамжийн судалгаа
- DANCE challenge-ын хаалт
- OPEN MIC зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулав.





**Хонгор сумын Соёлын төв** нь тус өдөрлөгийг аймгийн Төв номын сан, Музей, Залуучууд театр, Бүжгийн холбоо зэрэг соёл, урлагийн байгууллагуудтай болон сумын ЗДТГ, сумын СӨББ, ЕБС-ийн сургууль, сумын Ахмадын хороотой хамтран зохион байгууллаа. Соёлын орон зай нээлттэй өдөрлөгийн үеэр:

- Манголин хөгжмийн эмэгтэй цөөхүүл хамтлаг
- МУГЖ, дуучин Дагийсүрэн "Ээжийнхээ ачийг яаж хариулна даа"
- Дархан-Уул аймгийн Музейн ажилтан Наранцэцэг "Хорол, Үүчүүр" тоглоомын үүсэл хөгжлийн тухай мөн, хэрхэн тоглох талаар
- Угалз төвийн МУСТА Т.Оюунчимэг багшийн шавь нар "Уран нугаралтын үзүүлбэр"
- 14 дүгээр сургуулийн сурагчид "Цэцгийн үнэртэй нутаг"
- Хонгор сумын Ахмад уран бүтээлчид "Ардын хөгжмийн цөөхүүл"
- 14 дүгээр сургуулийн сурагч Эрхсаран, Ариун-Эрдэнэ "Даашинз"
- Бүжгийн багш Х.Оюунсүвд "Флаш моб"
- Дархан-Уул аймгийн Нийтийн цэнгээнт бүжгийн холбоод өөр өөрийн үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд урлаг, соёлоор үйлчилсэн.





**Орхон сумын Соёлын төв нь** Соёлын ажилтны өдрийг 1997 оноос хойш ашиглалтгүй байсан сумын Соёлын төвийн 2 давхарын 14 өрөөг орон нутгийн хөгжлийн сангийн 285.000.000 /хоёр зуун наян таван сая/ төгрөгөөр засварласан амжилтаар угтлаа. Соёлын төвийн барилгын хоёр давхар ашиглалтад орсноор хурлын болон бүжгийн заал, шатар, даам, морин хуур, ёочин зэрэг дугуйлан секц хичээллэх бүрэн боломжтой болсон. Мөн соёлын төвийн дэргэд дуу бичлэгийн студи байгуулахаар нэг өрөөг тусгай акустик хавтангаар тохижуулжээ.

Тус төвийнхөн Соёл, урлагийн ажилтны өдрийг сумын ЗДТГ, сумын СӨББ, ЕБС-ийн сургуультай хамтран шинэ номын үзэсгэлэн, Орон нутаг судлах танхимын үзмэрийн үзэсгэлэн, танилцуулга, Морин хуур, ёочин хөгжмийн дугуйлангийн танилцуулга, бүртгэл, ахлах, дунд ангийн сурагчдын дунд OPEN MIC, нийтийн цэнгээнт бүжиг зэргийг зохион байгуулав.

Монголын Улсын Соёл урлагийн ажилтны 29дэх өдрийн баярт зориулсан баярын Нээлттэй өдөрлөг 2022 оны 09дүгээр сарын 08-ны өдрийн 11 цагт Соёлын төвийн урд талбайд зохион байгуулагдах тул та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна.

### СОЁЛЫН ОРОН ЗАЙ

- 1. 11<sup>00</sup> цагаас**
  - Шинэ номын үзэсгэлэн
  - Орон нутаг судлах танхимын үзмэрийн үзэсгэлэн, танилцуулга (шинээр элсэн орсон 1 дүгээр ангийн сурагчид)
  - Морин хуур, ёочин хөгжмийн дугуйланд сонгон шалгаруулалтаар шалгаж авна.
- 2. 16<sup>00</sup>-19<sup>00</sup> цагаас**
  - "Орөн тик Орхон" (дунд, ахлах ангийн сурагчдын дунд)
  - Нийтийн цэнгээнт бүжиг 18 наснаас эхэлж үргэвдэг урьж байна.

Жич: Дугуйлан үнэ төлбөргүй.





## СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН АЖИЛТНУУДЫН ХҮҮХДҮҮДЭД ХҮҮХДИЙН ПАРКАД ТОГЛОХ ЭРХИЙН БИЧИГ ОЛГОВ

**2022 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр:** Тус өдөр аймгийн Соёл, урлагийн газраас Дархан хотын соёл, амралтын хүрээлэнтэй хамтран соёл, урлагийн салбарт ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг хүүхдүүдэд 4 тоглоомон дээр үнэ төлбөргүй тоглох эрхийн бичиг олголоо. Нийт 300 гаруй хүүхэд хамрагдав. Ийнхүү тэмдэглэлт өдрөөр гэр бүлээрээ амарч зугаалах боломж олгосонд соёлын ажилтнууд талархалтай байв.



### СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДРИЙГ ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШНИЙ УДИРДЛАГУУД БОЛОН ИРГЭД, ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧИЛАН ТАНИУЛСАН БАЙДАЛ:

Соёлын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгж, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон бүх шатны Засаг дарга нарт Соёлын тухай хуулийг сурталчлан хэрэгжилтийг ханган хамтран ажиллахыг уриалсан юм.

Энэ хүрээнд Дархан-Уул аймгаас УИХ-д сонгогдсон гишүүдэд болон Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат, аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Засаг даргын орлогч Б.Жавхлан, аймгийн ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Н.Цасчихэр нарын хэлтэс, агентлагийн дарга нарт, Дархан сумын Засаг дарга Т.Тулга нарын сумдын Засаг дарга нарт “Соёлын орон зай-Нээлттэй өдөрлөг”-т хүрэлцэн ирж оролцох урилга хүргүүлээ.

Мөн Дархан-Уул аймгийн иргэдэд урилга, мэндчилгээг орон нутгийн хэвлэл мэдээллийн сувгаар болон цахим хаяг, сошиалаар хүргэж ажиллалаа.

“Хандлагаа өөрчилъе -Хамтдаа бүтээцгээе” уриан дор “Соёлын орон зай”-г бий болгох санаачилга өрнүүлсэн олон талт үйл ажиллагааг орон нутгийн DBS, RGB,

аймгийн

УРИЛГА

ЭРХЭМ ХҮНДЭТ ДАРХАНЧУУД ТА БҮХНИЙГ

"СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДӨР"- ИЙН НЭЭЛТЭЙ ӨДӨРЛӨГТ ХҮРЭЛЦЭН ИРЭХИЙГ УРЬЖ БАЙНА.

Бүтээлч хотын соёлын орон зайг хамтдаа бүрдүүлцгээе.

Хаана: Дархан-Уул аймгийн Найрамдал талбай  
Хэвээ: 2022 оны 09 дүгээр сарын 10-ны 13:00 цагт

МЭНДЧИЛГЭЭ

Манай улсад соёл, урлагийн ажилтны өдрийг 1993 оноос тэмдэглэн өнгөрүүлж эхэлснээс хойш 29 дах жилтэйгээ золгож байна.

Өнөө жилийн хувьд соёл, урлагийн салбарынхан маань бүтээлч хотын "Соёлын орон зай" бий болгох ажлыг улс орон даяар өрнүүлэн бүх шатны ИТХ, Засаг дарга нар болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд Соёлын тухай хуулийг сурталчлан хамтран ажиллахыг уриалж буйгаараа онцрогтой юм.

Эх орнымоо урлаг соёлыг тасралтгүй хөгжүүлэн хойч үеэд өслүүлэн уламжилж, урлаг олон арга түмэндээ шинэ уран бүтээлийг өргөн барихын төлөө цаг ямагт хичээнгүйлэн ажиллаж ирсэн соёл, урлагийн салбарын нийт ажилтнууд, уран бүтээлчид, үе үеийн ахмадууд, тэдгээрийн гэр бүлд нь чин сэтгэлийн талархан илэрхийлж баярын мэнд хүргэе.

ХҮНДЭТГЭСЭН  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

### ТАЙЛАН БИЧСЭН:

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.ОТГОНБАЯР

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.СОЁЛ-ЭРДЭНЭ